

Таны хөдөлмөрийн хөлсийг өгөхгүй байна уу? Таныг заналхийлж байна уу? Чехийн эрх бүхий байгууллагуудад хандахад тусламж хэрэгтэй байна уу? Та хүнд хэцүү нөхцөлд байгаа бөгөөд юу хийх ёстойгоо мэдэхгүй байна уу? Та шаардлага хангаагүй нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна уу?

## ТАНЫ ХӨДӨЛМӨРИЙГ МӨЛЖИХИЙГ БҮҮ ЗӨВШӨӨР!



ТА БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ИРГЭН  
ЭСВЭЛ ГАДААДЫН ИРГЭН БАЙХААС ҮЛ  
ХАМААРАН ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ХҮН  
БҮРД ТЭГШ ҮЙЛЧИЛДЭГ.

### ЮУГ АНХААРАХ ЁСТОЙ ВЭ:

- » Ажил олгогч тань хөдөлмөр эрхлэлтийн гэрээний бичгээр үйлдсэн эх хувийг тань танд өгөөгүй юу?
- » Таны ажил олгогч эсвэл зуучлагч цалинг тань өгөхгүй байна уу?
- » Танд цалингийн хамгийн доод/ батлагдсан хэмжээнээс бага цалин өгч байна уу?
- » Ажил олгогч тань таныг долоо хоногт 40 цагаас эсвэл өдөрт 12 цагаас илүү цагаар ажиллуулж байна уу?
- » Хүлээн зөвшөөрөөд, илүү цагаар ажилласан тохиолдолд танд илүү цагийн хөлс нөхөж олгохгүй байна уу?
- » Та бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэл эсвэл ийм заналхийлэлд өртөж байна уу?
- » Та эрүүл ахуй, эрүүл мэнд эсвэл аюулгүй байдлыг хангаагүй нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна уу?
- » Ажил олгогч тань таны өвчтэй чөлөө эсвэл амралтын мөнгийг төлөхөөс татгалзаж байна уу?
- » Таны бичиг баримтыг хурааж авсан эсвэл чөлөөтэй явах хувийн эрхийг тань хязгаарлаж байна уу?



Spolufinancováno  
Evropskou unií



Projekt EURES+3Z Up! Rozvíjíme služby zahraniční zaměstnanosti



Translated with the support  
of the European Labour Authority

Хэрэв танд ийм зүйлс тохиолдож буй бол **НЭН ДАРУЙ өөрийгөө хамгаалаарай** Мэргэжилтнүүдээс тусламж аваарай – холбоо барих мэдээллийг доороос харна уу.

- » Ойлгохгүй байгаа бичиг баримтандаа гарын үсэг бүү зураарай (жишээ нь. таныг төлөөлөх итгэмжлэл, торгууль төлөх зөвшөөрөл, цалингийн суутгал гэх мэт)!
- » Цалингийн цэсээ авах хүсэлт үргэлж гаргаж, үүнийгээ хадгалж байгаарай!
- » Ажил олгогч тань таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлж буй эсэхэд хяналт тавьж байгаарай!

Хүчээр хөдөлмөр эрхлүүлэх болон хөдөлмөрийн мөлжлөгийн бусад хэлбэр нь эрүүгийн гэмт хэрэг бөгөөд мөлжигч этгээд ноцтой шийтгэл хүлээдэг!

Хэрэв та асуудалд орсон бол Бүгд Найрамдах Чех Улсад хууль бусаар, бичиг баримтгүй оршин суудаг байсан ч гэсэн тусламж, хамгаалалт хүсэхээс бүү эмээгээрэй.



**Таны хэл дээр хууль эрх зүйн болон нийгмийн асуудлаар үнэ төлбөргүй тусламж үзүүлдэг байгууллагуудтай холбогдоорой.**

Гадаадын иргэдэд дэмжлэг үзүүлэх төв эсвэл Diakonie, Charita, La Strada, IOM зэрэг ашгийн бус байгууллагын Лавлах болон байгууллага, институт ба мэргэжилтнүүдийн Лавлах дээрх бусад байгууллагаас (**cizinci.cz**) бүс нутаг эсвэл асуудлын төрлөө сонгоорой



Та ажил олгогчийг шалгуулах гомдлыг (мөн онлайнар) **Мужийн хөдөлмөр эрхлэлтийн хянан шалгалтын газарт (suip.cz)** гаргаж болно



Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, тусламж дэмжлэгийн талаар илүү их мэдээлэл авах бол **Мужийн хөдөлмөр эрхлэлтийн хянан шалгалтын газрын (suip.cz)** Асуулт, Хариултын хэсгийг харна уу.



Холбоо барих мэдээлэл болон бусад хэрэгцээтэй мэдээллийг авахын тулд гар утсан дээрээ **Smart Migration** аппликейшныг суулгаарай

Та гэмт хэрэг үйлдэгдсэн гэж сэжиглэж буй бол Цагдаагийн газартай 158 дугаараар холбогдоорой.



Spolufinancováno  
Evropskou unií



Projekt EURES+3Z Up! Rozvíjíme služby zahraniční zaměstnanosti



Translated with the support  
of the European Labour Authority